



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/10

Алтрага

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Ерөнхий боловсролын сургуулийн түлш халаалт" 85,000,000 (наян таван сая) төгрөгийн өртөгтэй ажлыг нийлүүлэх аж ахуйн нэгж сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Батсанаа  
(Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан)  
Гишүүд: Ч.Буяаннэмэх  
(ЕБС-ийн нярав)  
Н.Мягмарсүрэн  
(ЕБС-ийн насан туршийн боловсролын багш)  
Ө.Баасанхүү  
(ЕБС-ийн нягтлан бодогч)  
Нарийн бичгийн дарга: П.Агаар  
(ЕБС-ийн сургалтын менежер)

2.2024 оны Орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Ерөнхий боловсролын сургуулийн түлш халаалт" нийлүүлэх ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгж сонгон шалгаруулах ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Г.Батсанаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010024